

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**
/2021 оны 3 дугаар улирал/

2021 оны 10 дугаар сарын 04

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/266 дугаар захирамжаар батлагдсан “Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”, төвийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn, [Smartdarkhan](https://www.facebook.com/Smartdarkhan) цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2021 оны 3 дугаар улиралд Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 13410 өргөдөл, гомдол ирүүлснээс 13041 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 369 өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн шатандаа явж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 13214 хүсэлт, 41 санал, 155 гомдол тус тус эзэлж байна. Иргэд ихэвчлэн тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээ, гарах, нэвтрэх зөвшөөрөл, халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн болон газар хүссэн тухай өргөдөл ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 422 өргөдөл, гомдол ирүүлснээс 380 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 42 иргэний өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 90 хувьтай байна. Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.ХҮРЭЛЧУЛУУН

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ТУНГАЛАГ